

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 9/03

Арвайхээр

Томуу, томуу төст өвчин, шинэ коронавирусийн
халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

“Томуу, томуу төст өвчний харуулдан тандалтын тогтолцоог өргөжүүлэх тухай” Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 дугаар тушаалын 2.3 дах заалт, Аймгийн Засаг даргын “Томуу, томуу төст өвчний тархалтыг бууруулах, шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай” 2020 оны А/28 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн хэмжээнд амбулаторийн нийт үзлэгийн 19,4 хувийг томуу, томуу төст өвчин эзэлж, 5 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, өндөр настнууд хүндэрч, эмнэлгийн орны ачаалал нэмэгдэж байгаа тул сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд дархлаажуулалтын үндэсний товллын дагуу 2 хүртэлх насны хүүхдийг дархлаажуулах, эрүүл мэндийн даатгалын цахим жор бичихээс бусад тусламж үйлчилгээг 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн гэрийн үйлчилгээнд бүрэн шилжүүлсүгэй.

Хоёр. Өрх сумын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрийн үйлчилгээнд бүрэн шилжүүлсэн талаарх мэдээллийг ард иргэдэд шуурхай хүргэн, тусламж үйлчилгээг чирэгдэлгүй, чанартай үзүүлж, жирэмсэн эмэгтэйчүүдийг товлот хугацаа харгалзахгүйгээр гэрээр тогтмол үзэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээллээр хангах, ялангуяа отор нүүдлээр явж буй жирэмсэн эмэгтэйчүүдийн судалгааг нягтлан, эргэлт хяналтыг орон нутгийн удирдлагуудтай хамтран зохион байгуулахыг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт даалгасугай.

Гурав. Эмнэлгийн орны ачааллыг зохицуулах, орны тоог нэмэгдүүлэх, нэмэлт эмнэлэг дэлгэх төлөвлөгөөг шинэчлэн түүнийг шуурхай шат дараатай хэрэгжүүлэх, эрсдэлтэй бүлгийн өвчтөнд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, хүнд болон хүндэвтэр өвчтөнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн зөвлөх эмч нараас цаг алдалгүй зөвлөгөө авч, өвчлөл,


018900007

хүндрэлээс сэргийлэх ажлыг зохион байгуулахыг Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Томуу, томуу төст өвчин, шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэхэд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлж, тусгаарлах өрөөг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/293 дугаар тушаалын дагуу бэлтгэн, сэжигтэй тохиолдолд ажиллах багийг томилон, сургаж, бэлэн байдлыг хангуулах, ард иргэдэд урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол хүргэхийг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Зооноз өвчин судлалын төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн захирал, дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Тав. Тушаалын хэрэгжилтийг хангуулахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс /М.Золзаяа/, Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Ю.Ичинноров/, хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс /Я.Жаргал/ нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ